

## 2020 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2020 оны 4 дүгээр сард эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдлийн мэдээг 7 байгууллага /УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, НЭМГ/ ирүүлсэн. ГССҮТ, УАУТХ эмнэлгүүдээс мэдээ ирээгүй.

### Нэг. Амбулаторийн үзлэгийн хүлээгдэл:

2020 оны 4 дүгээр сард 640 үйлчлүүлэгч өдөртөө үйлчлүүлсэн байна. 1 ба түүнээс дээш хоногоор хүлээсэн 548 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна. Тухайлбал:

УНТЭ 147, УХТЭ 6, УГТЭ 107, ХСҮТ 342 хүлээгдэл тус тус бүртгэгдсэн байна. Харин ЭХЭМҮТ, СЭМҮТ, НЭМГ амбулаторийн хүлээгдэлгүй ажилласан байна. Үүнийг өмнөх сарын хүлээгдэлтэй харьцуулан авч үзвэл ХСҮТ-ийн хүлээгдэл буурч, УНТЭ, УХТЭ УГТЭ-ийн хүлээгдэл өссөн үзүүлэлттэй гарсан байна.

УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ-ийн 2020 оны 4 дүгээр сарын амбулаторийн хүлээгдлийг харьцуулсан нь:



Амбулаторийн хүлээгдлийг ЭМБ-аар авч үзэхэд:

**УНТЭ**-ийн 8 кабинетад 147 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 146 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн байна. Үүнд:

Бөөр судлалын кабинетад 1, мэдрэл судлалын кабинетад 10, нүд судлалын кабинетад 10, нүдний даралтын кабинетад 4, чих, хамар хоолойн кабинетад 27, булчирхай судлалын кабинетад 1, урологийн кабинетад 49, хоол боловсруулах судлалын кабинетад 45 үйлчлүүлэгч тус бүр 1 ба түүнээс хоногийн хүлээгдэлтэй бүртгэгдсэн байна.

**УХТЭ**-т нийт 3 кабинетад 6 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын амбулаторийн хүлээгдлээс 3 хүлээгдлээр нэмэгдсэн байна. Үүнд:

Мэс заслын кабинетад 1, уламжлалт эмилгээний кабинетад 1, булчирхай судлалын кабинетад 4 үйлчлүүлэгч тус бүр 1-ээс 4 хоногийн хүлээгдэлтэй үйлчлүүлсэн байна. Өдөртөө 328 үйлчлүүлэгч үйлчлүүлсэн байна.


**УГТЭ**-ийн 3 кабинетад нийт 107 хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 3 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн байна. Үүнд:

Зүрх судасны кабинетад 56, уушигны кабинетад 17, мэдрэл судлалын кабинетад 34 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 405 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

**ХСҮТ**-ийн 12 кабинетад нийт 342 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Энэ эь өмнөх сарын хүлээгдлээс 68 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр буурсан байна. Үүнд:

Мэс заслын кабинетад 7, зүрх судасны кабинетад 27, толгой хүзүүний мэс заслын кабинетад 28, туяа эмчилгээний кабинетад 19, химийн кабинетад 48, хөнгөвчлөх тусламж үйлчилгээний кабинетад 9, цээжний хөндийн мэс заслын кабинетад 43, элэг цөс, нойр булчирхайн кабинетад 68, Гепатологийн кабинетад 16, ангиографын кабинетад 29, эмэгтэйчүүдийн мэс заслын кабинетад 48 хүлээгдэл нь 1 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй байна. Өдөртөө үйлчлүүлсэн 163 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.


УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ-ийн 2020 оны 4 дүгээр сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



### Хоёр. Оношлогооны кабинетийн хүлээгдэл:

2020 оны 4 дүгээр сард 560 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлж 353 үйлчлүүлэгч хүлээж үйлчлүүлсэн байна. Энэ нь өмнөх сарын оношлогооны кабинетын хүлээгдлээс 32 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ-ийн оношлогооны кабинетын хүлээгдэл өмнөх сарынхаас нэмэгдсэн бол СЭМҮТ-ийн хүлээгдэл буурсан байна. Үүнд:

УНТЭ 31, УХТЭ 6, УГТЭ 100, СЭМҮТ 45, ХСҮТ 171 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн бол ЭХЭМҮТ оношлогооны хүлээгдэлгүй үйлчилсэн байна.



Оношлогооны хүлээгдлийг ЭМБ-аар авч үзэхэд:

**УНТЭ**-ийн оношлогооны 7 кабинетад 31 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх сарын хүлээгдлийн тооноос 25 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн байна. Үүнд:

Рентген зургийн оношлогооны кабинетад 2, хэвлийн ЭХО-ны кабинетад 8, тархины цахилгаан бичлэгийн кабинетад 1, доплеро-графийн оношлогооны кабинетад 1, бүдүүн гэдэсний дурангийн кабинетад 7, зүрхний ЭХО-ны кабинетад 11, КТТ-ын кабинетад 1 үйлчлүүлэгч тус бүр 2-оос дээш хоногийн хугацаатай хүлээгдэл байна.

**УХТЭ**-т нийт оношлогооны 7 кабинетад нийт 224 үйлчлүүлэгч үйлчлүүлсэнээс 218 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн бол 6 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 2 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн байна. Үүнд:

Зүрхний цахилгаан бичлэгийн кабинетад 5, тархины цахилгаан бичлэгийн кабинетад 1 үйлчлүүлэгч тус бүр 1-3 хоногийн хугацаатай хүлээгдэл байна.

**УГТЭ**-ийн 8 кабинетад нийт 250 үйлчлүүлэгч үйлчлүүлсэнээс 150 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн бол 100 үйлчлүүлэгч хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд: Рентген зургийн кабинетад 16, зүрхний цахилгаан бичлэгийн кабинетад 52, хэвлийн ЭХО-ны кабинетад 32 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

**СЭМҮТ**-ийн эмгэг сэтгэл судлалын оношлогооны кабинетаар нийт 98 үйлчлүүлэгч үйлчлүүлсэнээс 53 үйлчлүүлэгч өдөртөө үйлчлүүлж 45 үйлчлүүлэгч 2 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх сарын хүлээгдлээс 35 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр буурсан байна.

**ХСҮТ**-ийн 8 кабинетад нийт 310 үйлчлүүлэгч үйлчлүүлсэнээс 139 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн бол 171 үйлчлүүлэгч хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд: Рентген зургийн кабинетад 42, зүрхний цахилгаан бичлэгийн кабинетад 28, хэвлийн эхоны кабинетад 71, ходоодны дурангийн кабинетад 24, бүдүүн, шулуун гэдэсний дурангийн кабинетад 4, бамбайн эхо 2 үйлчлүүлэгч тус бүр 2 ба түүнээс дээш хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

**УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ-ийн оношлогооны кабинетийн 2020 оны 3, 4 дүгээр сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:**

№	Үзлэгийн кабинетын нэр	УНТЭ		УХТЭ		УГТЭ		СЭМҮТ		ХСҮТ	
		3 сар	4 сар	3 сар	4 сар	3 сар	4 сар	3 сар	4 сар	3 сар	4 сар
1	Рентген зураг	-	2	-	-	12	16	-	-	28	42
2	Зүрхний цахилгаан бичлэг	-	-	-	5	61	52	-	-	44	28
3	Эхо /хэвлий/	-	8	1	-	25	32	-	-	28	71
4	Бамбайн ЭХО	-	-	-	-	-	-	-	-	-	2
5	Ходоодны дуран	6	-	-	-	-	-	-	-	33	24
6	Холтер	-	-	-	-	-	-	-	-	-	-
7	Тархины цахилгаан бичлэг	-	1	3	1	-	-	-	-	-	-
8	Допплеро-графи	-	1	-	-	-	-	-	-	-	-
9	Нүдний уг харах	-	-	-	-	-	-	-	-	-	-
10	MRI	-	-	-	-	-	-	-	-	-	-
11	Бүдүүн гэдэсний дуран	-	7	-	-	-	-	-	-	-	4
12	Зүрхний эхо	-	11	-	-	-	-	-	-	-	-
13	КТГ	-	1	-	-	-	-	-	-	1	-
14	Эмгэг сэтгэл судлал	-	-	-	-	-	-	80	45	-	-
<b>Нийт</b>		<b>6</b>	<b>31</b>	<b>4</b>	<b>6</b>	<b>98</b>	<b>100</b>	<b>80</b>	<b>45</b>	<b>134</b>	<b>171</b>

**Дүгнэлт:** 2020 оны 4 дүгээр сард 560 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлж 353 үйлчлүүлэгч хүлээж үйлчлүүлсэн байна. Энэ нь өмнөх сарын оношлогооны кабинетын хүлээгдлээс 31 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Сүүлийн хоёр сард УНТЭ, ХСҮТ-үүдийн рентген зургийн оношлогооны кабинет, зүрхний цахилгаан бичлэгийн оношлогооны кабинет, хэвлийн ЭХО-ны оношлогооны кабинет, ходоодны дурангийн кабинетүүдэд дараалан хүлээгдэл бүртгэгдсэн байна.

**Гурав. Лабораторийн шинжилгээний хүлээгдэл:**

2020 оны 4 дүгээр сард мэдээ ирүүлсэн УНТЭ, УХТЭ, УГТЭ СЭМҮТ, ЭХЭМҮТ, ХСҮТ эмнэлгүүд лабораторийн шинжилгээний хүлээгдэлгүй ажилласан байна.

**Дөрөв. Хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:**

2020 оны 4 дүгээр сард ЭХЭМҮТ хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдэлгүй ажилласан бол УНТЭ, УХТЭ, УГТЭ, СЭМҮТ, ХСҮТ эмнэлгүүдийн бүртгэн мэдээлснийг нэгтгэн дүгнэв.

Хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдлийг ЭМБ-аар:

**УХТЭ**-ийн хэвтүүлэн эмчлэх тасагт нийт 50 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдлээс 21 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн байна. Үүнд: Мэс заслын тасагт 15, бөөр судлалын тасагт 2, зүрх судасны тасагт 15, мэдрэлийн

тасагт 5, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны тасагт 13 үйлчлүүлэгч 3 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй үйлчлүүлсэн байна.

**УГТЭ**-ийн хэвтэн эмчлүүлэх 7 тасгийн нийт 157 хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 6 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үүнд:

Зүрх судасны тасагт 3, мэс заслын тасагт 2, мэдрэлийн тасагт 10, чих хамар хоолойн тасагт 48, хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт 6, мэдрэлийн мэс заслын тасагт 38, зүрхний мэс заслын тасагт 50 үйлчлүүлэгчийн хүлээгдэл 3 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй бүртгэгдсэн байна.

**СЭМҮТ**-ийн стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт нийт 93 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх сарын хүлээгдлээс 10 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн байна. Үүнд: 3-6 хоногийн хүлээгдэлтэй 17, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 21, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 55 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.


**ХСҮТ**-д нийт 409 хүн хэвтэн эмчлүүлснээс 71 үйлчлүүлэгч хүлээгдэлгүй, 338 үйлчлүүлэгч хүлээж үйлчлүүлсэн байна. Энэ нь өмнөх сарын хүлээгдлээс 57 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн байна. Үүнд:

Мэс заслын тасагт 4, элэг, цөс, нойр булчирхайн тасагт 20, химийн тасагт 75, хөнгөвчлөхийн тасагт 22, ангиографийн тасагт 64, дурангийн тасагт 2, өдрийн химийн эмчилгээний тасагт 151 үйлчлүүлэгчийн хүлээгдэл 3 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй бүртгэгдсэн байна.

**УХТЭ, УГТЭ, СЭМҮТ, ХСҮТ-үүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн 2020 оны 4 дүгээр сарын хүлээгдлийг тасгаар харьцуулсан нь:**

№	ҮЗЛЭГИЙН КАБИНЕТЫН НЭР	УХТЭ	УГТЭ	СЭМҮТ	ХСҮТ	НИЙТ
1	Бөөр судлалын тасаг	2				2
2	Зүрх судасны тасаг	15	3			18
3	Мэс заслын тасаг	15	2		4	21
4	Мэдрэлийн тасаг	5	10			15
5	Чих хамар хоолой тасаг	-	48			48
6	Мэдрэлийн мэс заслын тасаг	-	38			38
7	Стрессээс шалтгаалсан сэтгэцийн эмгэг судлалын тасаг	-		93		93
8	Элэг, цөс, нойр булчирхайн тасаг	-			20	20
9	Хими эмчилгээний тасаг	-			75	75
10	Хөнгөвчлөх эмчилгээний тасаг				22	22
11	Ангиографийн тасаг	-			64	64
12	Хоол боловсруулах эрхтэн судлалын тасаг	13	6			19
13	Зүрхний мэс заслын тасаг		50			50
14	Дурангийн тасаг				2	2
15	Өдрийн хими эмчилгээний тасаг				151	151
<b>Нийт хүлээгдэл</b>		<b>50</b>	<b>157</b>	<b>92</b>	<b>338</b>	<b>638</b>

**УХТЭ, УГТЭ, СЭМУТ, ХСҮТ-үүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн 2020 оны 4 дүгээр сарын хүлээгдлийг хоногоор харьцуулсан нь:**



**Дүгнэлт:** УНТЭ-ийн хэвтүүлэн эмчлэх тасгууд хүлээгдэлгүй ажилласан байна. УХТЭ, УГТЭ, СЭМУТ, ХСҮТ-ийн хэвтүүлэн эмчлэх тасгуудад 3-6 хоногийн хүлээгдэлтэй 165 үйлчлүүлэгч, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 269 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 202 үйлчлүүлэгч, 1 сараас дээш хоногийн хүлээгдэлтэй 2 үйлчлүүлэгч нийт 638 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээсэн байна.

**Тав. НЭМГ-ын харьяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:**

НЭМГ-ын харьяа 3 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнд:

1. Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн мэдрэлийн тасагт 14, дотрын тасагт 49, ахмадын эмнэлэгт 136 орны хүлээгдэл;
2. Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн дотрын тасагт 1;
3. Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвийн мэдрэлийн тасагт 14, дотрын тасагт 56 үйлчлүүлэгчийн хүлээгдэл тус тус 3 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэл бүртгэгдсэн байна.

**НЭМГ-ын харьяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдлийг хоногоор харьцуулбал:**

№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	СХДЭМТ	ХУДЭМТ	НДЭМТ
			4 дүгээр сар		
1	Мэдрэл	Ор хүлээж байгаа өвчтөний тоо	14	-	14
		1-3 хоног	-	-	4
		3-6 хоног	-	-	5
		7-14хоног	7	-	3
		15-30 хоног	7	-	2


		1 сараас дээш	-	-	-
2	Дотор	Ор хүлээж байгаа өвчтөний тоо	49	1	56
		1-3 хоног	-	-	25
		3-6 хоног	8	1	21
		7-14хоног	30	-	8
		15-30 хоног	11	-	2
		1 сараас дээш	-	-	-
3	Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа өвчтөний тоо	136	-	-
		1-3 хоног	10	-	-
		3-6 хоног	19	-	-
		7-14хоног	37	-	-
		15-30 хоног	70	-	-
		1 сараас дээш	-	-	-

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 4 дүгээр сард нийт 20433 дуудлага бүртгэгдсэн нь өмнөх сарын дуудлагаас 577 дуудлагаар буурсан байна. Нийт дуудлагын 55.9%-ийг 0-20 минутад, 29.9 %-ийг 21-40 минутад, 10.2 %-ийг 41-60 минутад, 4 %-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

**Нийслэлийн түргэн тусламжийн төвийн тусламж үйлчилгээний  
2020 оны 1 дүгээр сараас 4 дүгээр сарын хүлээгдлийн мэдээ**

№	Үзүүлэлт	1 сар		2 сар		3 сар		4 сар	
		Дуудлагын тоо	Хувь	Дуудлагын тоо	Хувь	Дуудлагын тоо	Хувь	Дуудлагын тоо	Хувь
1	Нийт дуудлага	39812	100%	27322	100%	21010	100%	20433	100%
2	Хүлээгдлийн минут	0-20 минут	33.4%	44.0%	46.5%	55.9%			
3		21-40 минут	29.8%	36.4%	32.9%	29.9%			
4		41-60 минут	17.6%	15.1%	13.4%	10.2%			
5		1 цагаас дээш	19.2%	4.5%	7.2%	4.0%			

### Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2020 оны эхний 4 сарын хүлээгдэл



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ  
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ЛИЦЕНЗИЙН АЛБА